



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2022/103/НА-СА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр

Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал.....	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
4. Аудитын илрүүлэлт.....	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДХББЗГ	Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.02.25 № 208
танай 2022.07.25 -ны № 7-10/80 -Т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.АЗЖАРГАЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалтын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалтын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР


009020306

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,231,290,239.31</u>	<u>2,122,237,754.31</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,178,126,497.31	2,122,237,754.31
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,178,126,497.31	2,122,237,754.31
3121	Төгрөг	1,178,126,497.31	2,122,237,754.31
31211	Төрийн сангийн харилцах	1,178,126,497.31	2,122,237,754.31
33	АВЛАГА	53,163,742.00	-
335	Бусад авлага	53,163,742.00	-
3351	Байгууллагаас авах авлага	53,163,742.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,231,290,239.31</u>	<u>2,122,237,754.31</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,231,290,239.31</u>	<u>2,122,237,754.31</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,231,290,239.31	2,122,237,754.31
413	Өглөг	1,231,290,239.31	2,122,237,754.31
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,178,126,497.31	2,122,237,754.31
41350	Зээлийн хүүгийн өглөг		
4136	Бусад өглөг	53,163,742.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	53,163,742.00	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,231,290,239.31</u>	<u>2,122,237,754.31</u>

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,938,598,249.00	5,748,618,436.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,938,598,249.00	5,748,618,436.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,938,598,249.00	5,748,618,436.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,938,598,249.00	5,748,618,436.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,938,598,249.00	5,748,618,436.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,850,272.00	531,049,276.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,870,061.00	443,802,178.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	437,870,061.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	437,870,061.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	443,802,178.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	443,802,178.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,980,211.00	87,247,098.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,980,211.00	87,247,098.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,980,211.00	87,247,098.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,469,747,977.00	5,217,569,160.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,469,747,977.00	5,217,569,160.00
223001	Бусад хөрөнгө	4,469,747,977.00	5,217,569,160.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	-


Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн				-
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар




2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>6,270,203,300.31</u>	<u>7,619,048,895.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	419,582,930.31	1,817,266,717.00
120	Нийтлэг татварын бус орлого	419,582,930.31	1,817,266,717.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	419,582,930.31	1,817,266,717.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	419,582,930.31	1,817,266,717.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,850,620,370.00	5,801,782,178.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,850,620,370.00	5,801,782,178.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,850,620,370.00	5,801,782,178.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,238,821,165.00</u>	<u>1,404,204,736.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,238,821,165.00	1,404,204,736.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,154,677,212.00	1,316,957,638.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	489,373,854.00	873,155,460.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	489,373,854.00	873,155,460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,665,303,358.00	443,802,178.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,665,303,358.00	443,802,178.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,143,953.00	87,247,098.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	84,143,953.00	87,247,098.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	84,143,953.00	87,247,098.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,031,382,135.31</u>	<u>6,214,844,159.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,277,102,563.00	5,270,732,902.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,277,102,563.00	5,270,732,902.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,277,102,563.00	5,270,732,902.00
223001	Бусад хөрөнгө	5,277,102,563.00	5,270,732,902.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,277,102,563.00)</u>	<u>(5,270,732,902.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,245,720,427.69)	944,111,257.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,178,126,497.31
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,178,126,497.31	2,122,237,754.31



Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,902,839,200	5,714,535,080	(6,188,304,120)	48.0
УРСГАЛ ЗАРДАЛ	554,000,000	443,802,178	(110,197,822)	80.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554,000,000	443,802,178	(110,197,822)	80.1
Бараа үйлчилгээний бусад зардал	554,000,000	443,802,178	(110,197,822)	80.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,348,839,200	5,270,732,902	(6,078,106,298)	46.4
Бусад хөрөнгө	11,348,839,200	5,270,732,902	(6,078,106,298)	46.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,902,839,200	5,714,535,080	(6,188,304,120)	48.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,836,215,000	5,714,535,080	(2,121,679,920)	
Орон нутгийн төсвөөс	7,836,215,000	5,714,535,080	(2,121,679,920)	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,066,624,200	0	(4,066,624,200)	
Урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх	4,066,624,200	0	(4,066,624,200)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалтын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр хэрэгжүүлсэн.

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 7-10/80 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалт нь иргэдийг эрүүл аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх зэрэг төсөл, арга хэмжээнүүдийг санхүүжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Аймгийн ОНТХО нь тусдаа бие даасан байгууллага биш тул нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй бөгөөд санхүүгийн тайланг холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцүүлэн бэлтгэж байна.

ОНТХО-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд хөрөнгө оруулалтын хөтөлбөр, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд “ДХББЗГ” ОНӨААТҮГ-аас тогтмол хяналт тавьж, хяналтын зардлыг гэрээний дүнгээс санхүүжүүлжээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалтын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн 5,714,535.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 85,718.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 64,288.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалтын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 890,947.5 мянган төгрөгөөр буюу 72.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн дансанд их хэмжээний өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,178,126.5	2,122,237.7	944,111.2
Авлага	53,163.7	-	(53,163.7)
Урьдчилгаа	-	-	-
Нийт хөрөнгө	1,231,290.2	2,122,237.7	890,947.5
Өр төлбөр	1,231,290.2	2,122,237.7	890,947.5
Засгийн газрын хувь оролцоо			
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,231,290.2	2,122,237.7	890,947.5

Засгийн газрын 2019 оны “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 430 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах гэж заасны дагуу 2019 оноос хойш барьцаа хөрөнгийг байршуулж байна.

Тайлант хугацааны эхэнд 32 төсөл арга хэмжээний 1,178,126.5 мянган төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байснаас 16 төсөл арга хэмжээнд 423,155.5 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад олгож, 450,000.0 мянган төгрөгийн 1 төсөл арга хэмжээ хэрэгжихгүй болсон тул санхүүжилтийг Сангийн яаманд буцаан төвлөрүүлж, 2021 онд чанарын баталгаа, ажлын гүйцэтгэлд 1,817,266.7 мянган төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулснаар тус дансны эцсийн үлдэгдлийг 2,122,237.7 мянган төгрөгөөр илэрхийлжээ.

2019 оны эцэст коронавируст халдварын улмаас ажлыг хүлээн авах комисс ажиллаагүйгээс 53,163.7 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр, татаас санхүүжилтийн авлага үүссэн байсныг барагдуулсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого, зардлын дүн өмнөх оноос 810,020.2 мянган төгрөгөөр буюу 16.4 хувиар өссөн нь санхүүжилттэй холбоотой.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төсвийн төсөлд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг 5,057,617.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг аймгийн ИТХ-ын тогтоолоор хэвээр нь баталжээ.

Тайлант онд дээрх төсөвт 3 удаа өөрчлөлт оруулж, оны эцэст 11,902,839.2 мянган төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 11,902,839.2 мянган төгрөг баталснаас гүйцэтгэлээр 5,801,782.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, зардлын гүйцэтгэл 48.7 хувьтай гарсан нь ковид-19 цар тахал эрчимтэй тархаж, удаа дараа хөл хорио тогтоосон, урд хил хаалттай байснаас хамаарч бараа материалын үнэ огцом өсөж, татан авалт удааширсантай холбоотой байна.

2021 онд нийт 108 төсөл арга хэмжээнээс бүрэн дууссан 69, одоо хэрэгжиж байгаа 28 төсөл арга хэмжээнд 5,714,535.1 мянган төгрөгийг олгож, 87,247.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Замын сангийн хөрөнгө оруулалтаар 6 төсөл арга хэмжээг 554,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсанаас 5 төсөл арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлж, 443,800.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалтын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд худалдан авалтын 1,836,958.1 мянган төгрөгийн 37 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгснийг тайлант хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,836,958.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн ба энэ нь санхүүгийн тайлангийн зөрчил биш тул материаллаг алдаанд тооцоогүй болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 1,836,958.1 мянган төгрөгийн 37 гүйлгээг хугацаа хоцроон мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	1	1,836,958.1	-	-	-	-	-	-	1	1,836,958.1
	Дүн	1	1,836,958.1	-	-	-	-	-	-	1	1,836,958.1

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2022.02.25.

ХТ05430 @ 9022899